



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Шинжээчийн ёс зүйн дүрэм батлах тухай

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоохын тулд ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Шинжээчийн ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталж 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Шинжээчийн ёс зүйн дүрэм батлах тухай" Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны даргын 2012 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн A/01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



ШИНЖЭЭЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба / Цаашид “Алба” гэнэ/-ны шинжээчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлж, Шинжлэн шалгах алба болон шинжээчийн нэр төрийг хамгаалахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. Ёс зүйн дүрэм нь Монгол улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Осол, зөрчлийг шинжлэн шалгах чиглэлээр олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн актаар тогтоосон ёс зүйн хэм хэмжээтэй нийцсэн байна.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү дүрэм нь албаны нийт шинжээчдэд хамаарна.

2.2. Албаны шинжээчдээс бусад албан тушаалтан нь “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгож ажиллана.

Гурав. Ёс зүйн зарчим

3.1. Шинжээч нь өвөрмөц онцлог чиг үүрэг бүхий албан тушаалтан болохын хувьд шинжлэн шалгах үүргээ хэрэгжүүлэх явцад дараах зарчмыг баримтална.

- шударга ёсны;
- хуулийг дээдлэх;
- тэгш байдал,
- хариуцлага хүлээх;
- олон нийтэд үйлчлэх;

Дөрөв. Шинжээчийн ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс

4.1. Шинжээч нь энэ дүрмийн 3.1-д заасан зарчмын хүрээнд төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, нийтийн албаны үйлчилгээг үзүүлэхдээ дор дурдсан зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ:

4.1.1. шударга ёсны зарчмын хүрээнд: хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах;

4.1.2. хуулийг дээдлэх зарчмын хүрээнд: төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон нийтийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээдлэн сахих;

4.1.3. тэгш байдлын зарчмын хүрээнд: бусад нийтийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;